



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
АЖЛЫН АЛБА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84  
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2023.04.28 № 3 / 1743  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

“ХААН ГАЛ ТАМГА”  
ХЗХ-НЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Г.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Өөрчлөлт бүртгэсэн тухай

Танай хоршооноос 2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр ирүүлсэн сонгуульт гишүүдийн болон гүйцэтгэх захирлын өөрчлөлт бүртгүүлэх хүсэлт, холбогдох баримт бичгийг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Хорооны 2018 оны 245 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 8.2-т заасны дагуу хянаж, холбогдох бүртгэлд дараах өөрчлөлтийг бүртгэсэн болно. Үүнд:

№	Хамаарал	Овог, нэр	Тайлбар
1	Тэргүүлэгчдийн зөвлөл	Дарга	Ш.Нямсүрэн
2		Гишүүн	Ц.Чулуунцэцэг
3		Гишүүн	С.Нямдорж
4		Гишүүн	Н.Түвшингэрэл
5		Гишүүн	Н.Даваадулам
6	Хяналтын зөвлөл	Дарга	Н.Нямбаяр
7		Гишүүн	Н.Лхамсүрэн
8		Гишүүн	С.Сумъяа
9		Гишүүн	Ч.Цамбасүрэн
10		Гишүүн	Г.Цэрэннадмид
11	Зээлийн хороо	Дарга	Г.Энх-Амгалан
12		Гишүүн	Г.Даваажав
13		Гишүүн	Б.Хишигтогтох
14	Гүйцэтгэх захирал	Г.Энх-Амгалан	шинээр
15	Нягтлан бодогч	Г.Нямцоож	бүртгэлтэй

Гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад ажлын 15 хоногийн дотор бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлнэ үү.

Ирүүлсэн баримт бичигтэй танилцахад бүх гишүүдийн хурлын үеэр хурал зохион байгуулах тэргүүлэгч гишүүдийг сонгож, тэдгээр гишүүдээр хурлын шийдвэрт гарын үсэг зуруулж байгаа нь дээрх хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т “Бүх гишүүдийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх ба шийдвэрт тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна”, 33 дугаар зүйлийн 33.1-д “Бүх гишүүдийн хурлыг тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга, түүний эзгүйд тэргүүлэгчдийн зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч удирдана.”, 33.2-т “Бүх гишүүдийн хурлаас хурлын нарийн бичгийн дарга, тооллогын комиссыг сонгоно.” гэж тус тус заасантай нийцэхгүй байгаа тул бүх гишүүдийн хурлыг зохион байгуулахдаа хуульд заасан дэгийг дагаж мөрдөхийг зөвлөж байна.

ДАРГА



Г.ЖАМБААЖАМЦ

1518000507